



ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлээрээ ажилласан 8 жилд хийсэн ажлын тайлан /товч тоон үзүүлэлтээр/;
2. Өөрийн байгууллагын бусад эмнэлгийн мэргэжилтэнд зөвлөж, хамтран ажиллах, тэдэнд заан сургах чадвартай /баримт хавсаргах/ байх;
3. Монголын яаралтай тусlamжийн нийгэмлэгийн үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол оролцдог, түүнийгээ тодорхойлох (баримт хавсаргах), идэвхи санаачлагатай байх;
4. Гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх;
5. Бүтээлийн жагсаалтад яаралтай тусlamжийн нийгэмлэгийн “Яаралтай тусlamж” сэтгүүл /хамгийн багадаа 1/ болон бусад шинжилгээ судалгааны сэтгүүлд 2-оос доошгүй илтгэл /онол практикийн хуралд/ хэлэлцүүлсэн байх. Дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж /гарчиг ба өгүүлэл, илтгэл/ хавсаргана;
6. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд яаралтай тусlamжийн чиглэлээр мэргэшил дээшлүүлэх сургалтад зайлшгүй хамрагдсан байх, түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан /товч тоон үзүүлэлтээр/;
2. Бүс орон нутгийн эмнэлгийн мэргэжилтэнд зөвлөх, тэдний хөгжилд хувь нэмэр оруулсан /баримт хавсаргах/ байх;
3. Монголын яаралтай тусlamжийн нийгэмлэгийн үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол оролцдог, түүнийгээ тодорхойлох /баримт хавсаргах/, идэвхи санаачлагатай байх;
4. Бүтээлийн жагсаалтад яаралтай тусlamжийн нийгэмлэгийн “Яаралтай тусlamж” сэтгүүл /хамгийн багадаа 2/ болон бусад шинжилгээ судалгааны

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

сэтгүүлд 3-аас доошгүй өгүүлэл /онолын, тойм ба судалгааны өгүүлэл/ нийтлүүлж, 5-аас доошгүй /онол практикийн хуралд/ хэлэлцүүлсэн байх. Дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж /гарчиг ба өгүүлэл, илтгэл/ хавсаргана;

5. Гадаадад болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд яаралтай тусlamжийн чиглэлээр мэргэшил дээшлүүлэх сургалтад 1 сараас дээш хугацаагаар зайлшгүй хамрагдсан байх /туүнийгээ нотолсон баримтыг хавсаргах/;
6. Суралцагч эмч /резидент/ мэргэжилтнийг дагалдуулан сургаж, өөрийн мэдлэг, туршлагыг эзэмшигүүлсэн, нийгэмлэгээс зохиосон сургалтын ажилд идэвхитэй оролцсон байх;
7. Эмнэлзүйн сургагч багшийн сургалтад хамрагдаж дүүргэсэн байх /туүнийгээ нотолсон баримтыг хавсаргах/;
8. Залуу эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд чиглэсэн ажлын байрны богино хугацааны сургалтад хичээл заасан байх /хичээлийн хөтөлбөр ба бусад материалаар баталгаажуулах/;
9. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх;
10. Гадаад хэлний зохих мэдлэгтэй, түүнийгээ нотлох баримтыг /үнэмлэх, гэрчилгээ, мэргэжлийн дагуу орчуулсан ном, товхимол, материал/ хавсаргана.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сум дундын эмнэлэгт яаралтай тусlamжийн эмчээр тогтвортой суурьшилтай, тасралтгүй 20 ба түүнээс дээш жил ажилласан, шаардлага хангасан бол зөвлөх зэрэг горилох;
2. Мэргэшлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан /товч тоон үзүүлэлтээр гаргах/;
3. Салбар үндэсний түвшинд бусад эмнэлгийн мэргэжилтэнд зөвлөх, тэдний хөгжилд хувь нэмрээ оруулсан /баримт хавсаргах/ байх;
4. Монголын яаралтай тусlamжийн нийгэмлэгийн үлгэр жишээч гишүүн байх, үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол оролцдог, нийгэмлэгээс зохиосон сургалтыг ажилд идэвхитэй оролцсон байх;
5. Өмнөх зэрэг хамгаалснаас хойших бүтээлийн жагсаалт гаргах. Үүнд:
 - Монголын яаралтай тусlamжийн нийгэмлэгийн “Яаралтай тусlamж” сэтгүүл /хамгийн багадаа 3/ болон бусад шинжилгээ судалгааны сэтгүүлд 3-аас доошгүй өгүүлэл /онолын, тойм ба судалгааны өгүүлэл/ нийтлүүлсэн;
 - 8-аас доошгүй /онол практикийн хуралд/ хэлэлцүүлсэн байх /дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж гарчиг ба өгүүлэл, илтгэл хавсаргах/;
 - Өөрөө бичиж хэвлүүлсэн ном болон хамтран бүтээсэн номын тоо 2-оос доошгүй байх;
 - Хамтран гаргасан баталгаажуулсан оношилгоо, эмчилгээний удирдамж; /туүнийгээ нотолсон баримтыг хавсаргах/;

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

- Зохиогчийн эрх, ашигтай заавар, оновчтой саналын гэрчилгээний аль нэгийг авсан байх /түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах/;
- Эмнэлзүйн практикт бодитоор нэвтрүүлж үр дүнгээ өгсөн шинэ арга 2-оос доошгүй байх /түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах/;
- 6. Мэргэшлийн ажлаа чадварлаг санаачлагатай гүйцэтгэж ирсэн, энд дурдагдсан тусгай шалгуурыг ханган биелүүлж, хамт олондоо хүндлэгдсэн үлгэр жишээчээр ажиллаж байгаа, зөвлөх зэргийн шалгалтад орохыг зөвшөөрсөн байгууллагын тодорхойлолтод энэ талаар тусгасан байх;
- 7. Гадаадад болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд яаралтай тусламжийн мэргэшил дээшлүүлэх сургалтад 1 сараас багагүй хугацаагаар зайлшгүй хамрагдсан байх /түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах/;
- 8. Эмнэлзүйн сургагч багш болон эмнэлзүйн чиглүүлэгч багшийн сургалтад хамрагдаж дүүргэсэн байх /аль нэг нь байж болно, түүнийгээ нотолсон баримтыг хавсаргах/;
- 9. Суралцагч эмч (резидент) мэргэжилтнийг дагалдуулан сургаж, өөрийн мэдлэг, туршлагыг эзэмшүүлсэн, запуу эмч, сувилагчийн сургалтад оролцож хичээл заадаг /хичээлийн хөтөлбөр ба бусад материалаар баталгаажуулах/;
- 10. Мэргэшлээрээ зөвлөх, бие даан мэргэжлийн санал, дүгнэлт гаргах, сургалт явуулах түвшинд хүрсэн, өөрийгөө орлох хэмжээний шавь нарыг бэлтгэсэн байх;
- 11. Гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн /үнэмлэх, гэрчилгээ, мэргэжлийн дагуу орчуулсан ном, товхимол, материал/ байх.